

ACTA MONGOLICA
CENTRE FOR MONGOL STUDIES
National University of Mongolia

Том. 7 (291)

2007

015-022

Манж “али гали”-гийн тухай өгүүлэх нь

Цагаансар
(ӨМИС, МСДС)

Агуулгын товч: Манж үсэг бол монгол бичгийн түүхтэй нягт холбоотой нэг зүйлийн үсэг бичиг болно. Монгол үсэг бичгийн түүхэн дээр, монгол үсгийн суурин дээр зохиогдсон “али гали” гэдэг галиг үсгийн систем нь санскрит, төвд бурханы шашны номын монгол хэлний орчуулгад хэрэглэгдэж байсантай адилаар XVIII зууны дунд үеэр манж үсгийн суурин дээр зохиогдсон манж “али гали”-ийн систем нь бурханы шашны номын манж хэлний орчуулгад хэрэглэгдэх болов. Тус “али гали” нь санскрит ба төвд хэлний хоёр системд хуваагдана. Манж “али гали” нь манж үсгийн дүрс хэлбэрийн суурин дээр зохиогдож, бас санскрит, төвд хэлэнд л байх онцгой авиаанд тохируулан зохиосон шинэ дүрсүүдтэй байж, цөөнх байдалд монгол “али гали”-гийн дүрс хэлбэрийг зээлэн авсан байна.

Зангилаа үг: Манж “али гали”, санскрит хэлний ба төвд хэлний систем, дүрс хэлбэр

Монгол үсэг бичгийн түүхэн дээр галигийн хувиар хэрэглэгдсэн харь гадаадын үсэг бичгийн систем дотор хятад үсэг, араб үсэг ба төвд үсэг зэргээр галиглласан монгол хэлний материалууд нь тус тусынхаа онцлог ба үүрэг чадамжаараа монгол хэл, соёлын түүхэн агуулгыг баялагжуулсан байна. Тэдгээрээс гадна, бурханы ном судар орчуулах хэрэглээнд зориулан, санскрит, төвд бурханы нэр, хүн, газар орны нэр ба ном судрын нэр жич бурханы шашны нэр томъёоны зүйлсийг монгол хэлэнд орчуулан буулгахын төлөө, монгол үсгийн суурин дээр зохион найруулсан “али гали” гэгч галиг үсгийн систем нь 1586 оноос эхлэн монгол бурхан шашны орчуулгад тун өргөн хэрэглэгдэж байсныг бид тусгай судалгаандаа шинжилж өнгөрсөн билээ.¹ Монгол “али гали” (монгол галиг үсэг ч гэдэг) нь монгол үсгийн дүрс жич бичиглэх аргаар үндэс болгож, төвд, санскрит үсгийн дүрсээр хяналт болгон зарим үсгийн дүрсийг зохион хэрэглэснээс монгол үсгийн орчуулгад санскрит, төвдийн авиа бүхнийг нэлээд бүрэн дүүрэн галиглан буулгаж чадах болсон байна. Монгол “али гали”-гийн хэрэглэгдсэн нь монгол бурханы шашны орчуулгын үйлсэд төдийгүй бас монгол цагаан толгойн

¹ čayansara. a-a li g`a-a li üsüg-ün suduly-a. ulayanbayatur., 2005 on.

төгөлдөржил, цаашилбал бусад үндэстний хэл, үсэг бичгийн адилавтар үйлдэл бүхий галигийн системийн буй болж хэрэглэгдэхэд ч чухал нөлөө үзүүлсэн байна. Манж үсэг нь монгол үсгийн суурин дээр зохиогдсоноор үл барам, манж “али гали” ч монгол “али гали”-тай адилавтар үйлдэлтэйгээр зохиогдсон байна.

Манж “али гали”-г мөн манж галиг ч гэдэг. Тэр нь манж үсгийн дүрс ба бичиглэх аргын суурин дээр, монгол “али гали”-гийн шинээр нэмэгдсэн үсэг, дүрсийн зохиогдсон туршлагыг шингээн, төвд, санскрит бурхан шашны номын манж бичгийн орчуулгад зориулан зохиогдсон зүйл болно. Манж “али гали” бол санскрит, төвд бурханы нэр, хүн, газар орны нэр ба номын нэр жич бусад хамаа бүхий нэр томъёо, тарнийн үгийг буулган бичихэд хэрэглэгддэг галиг үсгийн систем болно.. Түүний эхлэн хэрэглэгдсэн цагийг манж сурвалж бичгийн судалгаадад бурханы ном судрын манж бичигт эхлэн орчуулсан цагтай холбон шинжилсэн нь илүү боловч тэдгээрийн дотор *Xu Цзинь Шань* аbugain дурдсанаар “*Tūn yün yün tūn*” (同文韵统) судраас эхэлсэн гэх нь илүү баталгаатай байна.² Манж “али гали” -г зохион найруулсан хүн бол яг “*Tūn yün yün tūn*” номыг эрхилэн найруулсан гуравдугаар дүрийн Жанжаа хутагт Ролбийдорж болно. Тус Жанжаа хутагт бол Тэнгэр тэтгэгч хааны үед улсын багшаар өргөмжлөгдсөн Чин улс даяар ихээр хүндэтгэгдсэн мөртөө төвд, монгол бурхан шашны үйлсэд гавьяа зүтгэл үзүүлсэн эрдэмт лам болно. Тэр бээр манж монгол бурханы номын орчуулгад ч туйлын их нэмэр оруулсан хүн болно. Үүнд онцгойлон дурдууштай нь түүний таван их мэргэжихүйн орны агуулга ба нэр томъёог төвлөрүүлэн багтааж өгүүлсэн төвд монгол хоёр хэлээр хавсарган гаргасан “Мэргэд гарагын орон” нэрт даяг болно. Тэр нь Тэнгэр тэтгэгчийн зарлигаар “Данжуур”-ыг монгол хэлнээ орчуулахад зориулж зохиосон толь бичиг болно. Жанжаа хутагт 1748 онд, Тэнгэр тэтгэгч хааны зарлигаар Хошууд чин ван *Юнь ло, Лю тун сюнь* зэрэг олон сайд нарын оролцоотойгоор “*Tūn yün yün tūn*” номыг эрхилэн найруулж, үүндээ төвд, монгол, хятад “али гали”-ийг жагсаахын хамт, манай тус удаагийн судалгаанд судлагдахуун болж байгаа манж “али гали”-г анх удаа найруулан гаргасан байна.

Хоёр. Манж “али гали” ба түүний хоёр зүйлийн систем

Бид юуны өмнө манж “али гали” бол шинэ үсэг (буюу дусал бинттэй манж үсэг)-ийн дүрс хэлбэрийн үндсэн дээр зохиогджээ гэдгийг тодорхойлох хэрэгтэй байна. Шинэ манж үсэг (дараачаар шууд манж үсэг гэж дөхөмчилнө) гэгч нь 1599 онд Нурхачийн зарлигийг үндэслэн монгол үсэгт ямар ч өөрчлөлт засалт хийсэнгүйгээр манж хэлээ тэмдэглэсэн тэрхүү хуучин манж үсэгтэй харьцуулан нэрийдсэн зүйл болох бөгөөд хуучин манж үсэгт дусал бинт тавьж бүтээсэн манж үсгийн шинэ нэгэн систем болно. Тэр нь хуучин манж үсгийн манж хэлийг бүрэн сайн тэмдэглэж үл чадах дутагдлыг нөхвөрлөсөн байна. Доор бид урьдаар манж үсгийн цагаан толгойн жагсаалтыг үзье.³

² qu jin šan. *yurbaduyar düri-yin janggiy-a qutuytu jiči tegün-ü jokiyaysan manju bičig-ün tarni-yin sine üsüg.* /dumdadu ulus-un töbed sudulul/, 1996 on-ii nilegedüger ququchaay-a.

³ Тус манж үсгийн цагаан толгойт Баосян профессорын найруулсан “Монгол үсэг бичгийн түүх”. (Өвөр Монголын Соёлын Хэвлэлийн Хороо/, 1998 оны хэвлэл)-ийг үндэслэн авч, Ху цзинь шань аbugain өмнө дурдсан зохиолоор хяналт болгон нөхвөрлөн засварлаж, үндсэндээ Ху цзинь шань аbugain галигийг хэрэглэсэн болно.

Эгииг үсэг:

✓ a ᠬ e ᠮ i ᠮ o ᠮ u ᠮ ö

Гийгүүлэгч үсэг:

✓ na ᠮ ne ᠮ ni ᠮ no ᠮ nu ᠮ nö

✓ ka ᠮ ko ᠮ ku ᠮ ga ᠮ go ᠮ gu ᠮ ha ᠮ ho ᠮ hö

✓ ba ᠮ be ᠮ bi ᠮ bo ᠮ bu ᠮ bö

✓ pa ᠮ pe ᠮ pi ᠮ po ᠮ pu ᠮ pö

✓ sa ᠮ se ᠮ si ᠮ so ᠮ su ᠮ sö

✓ ſa ᠮ ſe ᠮ ſi ᠮ ſo ᠮ ſu ᠮ ſö

✓ ta ᠮ te ᠮ ti ᠮ to ᠮ tu ᠮ tö

✓ da ᠮ de ᠮ di ᠮ do ᠮ du ᠮ dö

✓ la ᠮ le ᠮ li ᠮ lo ᠮ lu ᠮ lö

✓ ma ᠮ me ᠮ mi ᠮ mo ᠮ mu ᠮ mö

✓ ča ᠮ če ᠮ ri ᠮ čo ᠮ ču ᠮ čö

✓ ja ᠮ je ᠮ ji ᠮ jo ᠮ ju ᠮ jö

✓ ya ᠮ ye ᠮ yo ᠮ yu ᠮ yö

✓ ke ᠮ ki ᠮ ku ᠮ ge ᠮ gi ᠮ gu ᠮ he ᠮ hi ᠮ hö

✓ ka ᠮ ga ᠮ ha ᠮ ko ᠮ gu ᠮ hö

✓ ra ᠮ re ᠮ ri ᠮ ro ᠮ ru ᠮ rö

✓ fa ᠮ fe ᠮ fi ᠮ fo ᠮ fu ᠮ fö

✓ wa ᠮ we

ᠳ/tsa ᠳ/tsē ᠳ/tsi ᠳ/tsō ᠳ/tsu ᠳ/tsō
 ᠴ/tsa ᠴ/tsē ᠴ/tsi ᠴ/tsō ᠴ/tsu ᠴ/tsō
 ᠵ/za ᠵ/ze ᠮ/zi ᠮ/zō ᠮ/zu ᠮ/zō
 ᠮ/sy ᠮ/cy ᠮ/jy

Үүний суурин дээр зохиогдсон манж “али гали” нь мөн ч монгол “али гали” (монгол галиг) шигээр санскрит хэлний авиааг тэмдэглэсэн галигийн систем ба төвд хэлний авиааг тэмдэглэсэн галигийн систем гэж хоёр системд хуваагдана.

Бид урьдаар санскрит хэлний авиааны системийн манж “али гали”-ийг үзвэл:
Арван зургаан эгшгийн галиг:

ᠮ/a ᠮ/ā ᠮ/i ᠮ/ī ᠮ/u ᠮ/ū ᠮ/ri ᠮ/ī
 ᠮ/ii ᠮ/ū ᠮ/e ᠮ/e ᠮ/o ᠮ/ō ᠮ/am ᠮ/∞ ah

Гучин дөрвөн гийгүүлэгчийн галиг:

ᠮ/ka ᠮ/kha ᠮ/ga ᠮ/gha ᠮ/nga ᠴ/tsa ᠴ/tsha ᠴ/dsa ᠴ/dsha ᠮ/ñā
 ᠮ/la ᠴ/ña ᠮ/da ᠮ/pha ᠮ/ra ᠮ/ta ᠮ/tha ᠮ/da ᠮ/dha ᠮ/na
 ᠮ/pa ᠮ/phā ᠮ/ba ᠮ/bha ᠮ/ma ᠮ/ya ᠮ/ra ᠮ/la ᠮ/wa
 ᠮ/śa ᠮ/śa ᠮ/sa ᠮ/ha ᠮ/∞ gśa

Дараа нь төвд хэлний авиааны системийн манж “али гали”-ийг жагсаавал:
Төвд үсгийн цагаан толгойн галиг:

ᠮ/ka ᠮ/kha ᠮ/ga ᠮ/nga ᠮ/ca ᠮ/cha ᠮ/ja ᠮ/ñā
 ᠮ/ta ᠮ/tha ᠮ/da ᠮ/na ᠮ/pa ᠮ/phā ᠮ/ba ᠮ/ma
 ᠮ/ka ᠮ/kha ᠮ/ga ᠮ/nga ᠮ/ca ᠮ/cha ᠮ/ja ᠮ/ñā
 ᠴ/tsa ᠴ/tsha ᠴ/dsa ᠮ/wa ᠮ/zha ᠮ/za ᠮ/ha ᠮ/ya

✓ra *✓la* *✓sa* *✓sa* *✓ha* *✓a*

Төвд эгшиг үсгийн тэмдгийн галиг:

ऋ i *ऋ (ा)*, *ऋ (ा)*, *ऋ (ा ा) u* *ऋ (े ः े .. े - बागा a-d) e*

ऋ (ा ॒), *ऋ (ा ा)*, *ऋ (ा े) o* зэрэг болно.

Дээр жагсааснаас үзвэл, манж “али гали”-д манж хэлний авиатай тохиролцсон санскрит, төвд хэлний авиааг тухайн манж үсгийн дурсээр тэмдэглэж, манж хэлэнд байхгүй санскрит төвд хэлний авианд шинэ үсэг тэмдэг зохиож хэрэглэсэн байна. Түүнд санскрит хэлний 16 эгшиг ба төвд хэлний эгшгийг тэмдэглэхдээ үндсэн дээрээ манж үсгийнхээ уулын дурс тэмдгийг хэрэглэн, зарим онцгой авиа *aṁ aḥ*-д санскритын тус хоёр авианы *anusvara* тэмдэг (°) ба *visarga* тэмдэг(∞)-ийг авч << o >> *ऋ* *ऋ* *∞* >> мэтээр нэмэн тэмдэглэсэн байна. Санскрит төвдийн эгшиг үсгийг тэмдэглэсэн аргын хувьд манж “али гали”-д монгол “али гали” лугаа адилавтар тал байх мөртөө урт эгшгийг тэмдэглэсэн талаар түүнээс онцлогдох зүйл ч байна. Үүний тухай дараачаар нарийн ярина. Санскрит төвд хэлний гийгүүлэгч авиааг тэмдэглэхдээ манж хэлэнд байхгүй авиааг манж үсгийнхээ суурин дээр зохиосон шинэ дурсээр тэмдэглэжээ. Тухайлбал, манж хэлэнд санскрит хэлний дуутай, түрэлттэй гийгүүлэгч *gha*, *dsha*, *cha*, *bha*- хэлний урдуурх хамжин шүргэх *tsa*, *tsha*, *dsa* гийгүүлэгч, *śa* гийгүүлэгч ба хэл матирах *ta*, *tha*, *da*, *śa* гийгүүлэгч хамрын *nga*, *ṇa* гийгүүлэгч ба нийлмэл гийгүүлэгч *gṣa* зэрэг авиа байхгүй тул тэдгээрт тус тус << *ऋ*, *ऋ* *∞* >> зэрэг шинэ дурсуудийг зохиосон байна. Гэтэл төвд хэлний санскрит манж хэлэнд бүр байхгүй *ca*, *cha*, *ja*, *ña* гийгүүлэгчид түүний дуудлагыг үндэслэн хадсан << *ऋ* *ऋ* *ऋ* *ऋ* >> дурс зохиосон ба *zha*, *za*, *ṭha* зэрэг гийгүүлэгчид шинээр зохиосон << *ऋ*, *ऋ*, *ऋ*, *ऋ*, *ऋ* >> гэх дурсуудийг хэрэглэсэн байна.

Тэдгээр манж “али гали”-гийн шинэ дурсуудийг ажиглавал, Жанжаа хутагт Ролбийдоржоос дусал бинттэй манж үсгийн дусал ба бинтийн үйлдлийг уулынхаас нь хол өргөтгөн хэрэглэсэн нь тодорхой байна. Дусал бинттэй манж үсгийн цагаан толгойг ажиглавал, *a*, *e* эгшиг үсгийг харилцан ялгах ба *o*, *u*, *ö* эгшиг үсгийг харилцан ялгахад зориулан *e*, *u* хоёр үсгийн эгшиг үсгийн нуруунд л дусал тавьсан байдаг. Түүний гийгүүлэгч үсэгт *k*, *g*, *h* гурвыг тус тус << *ऋ (॒) ऋ (े) ऋ (॑)* >> гэж дусал ба бинтээр авиааны байр нь адил боловч авиаалах арга нь адил бус гурван авиааг ялан тэмдэглэсэн байна. Үүнээс гадна, хятад зээлээ үгийн *sy jy* (үнэндээ хятаад хэлний хэл матирах авиа [*ts*] [*ds*] хоёр авиа болно.) Хоёр зүйлийн авиааг мөн бинттэй үсэг << *ऋ* *ऋ* >>-аар тэмдэглэсэн төдий л байна. Гэтэл манж “али гали”-д санскритын хэл матирах авиа, түрэлтэй авиа, хамрын гийгүүлэгч *na* зэргийг бүр бинтэт үсгээр тэмдэглэснийг гаргавал, дуутай гийгүүлэгч *da*, *dha* -ийн *d*-г дусалтай << *ऋ* >> -аар тэмдэглэсэн байна.

Энэ маягаар үсгийн нэмэлт тэмдгийг улируулан хэрэглэсэн нь санскрит, төвд хэлний авианы төрөл зүйлийн олноос шалтгаалагдсан бөгөөд манж үсгийн үндсэн дурсээс үл салангирах гэсэн зохиогчийн уг санааны илрэл болох билээ.

Гурав. Манж “али гали” ба монгол “али гали”-г харьцуулах нь

1) Санскрит төвд хэлний *a* эгшгийн биеэ даасан дурс (*бууу уг дурс*) нь монгол “али гали”-д урагшилга (*𠂇*) -аар төгссөн байхад манж “али гали”-д харин орхиц хэлбэр (✓) -ээр (*𠂇 ka 𠂇 kha 𠂇 pa 𠂇 pha 𠂇 ba 𠂇 bha мэтсийг гаргавал*) байна.

2) Монгол “али гали”-д төвд үсгийн бага *a* (*ha*) -г түүний төвд үсгийн дурсээс ирсэн дурс << 𠂇 >> -ээр тэмдэглэжээ. Гэх мөртөө урт *a* (*ā*)-г << 𠂇 𠂇 >> -аар тэмдэглэсэн нь гадар хэлбэрийн талаар (*бичлэгийн талаар*) төвдөд санскритын урт эгшиг (*𠂇*) гэх мэтээр *ix a* үсэгт *bagaa* үсэг уяж илтгэсэнтэй холбоогүй шиг. (*bagaa a-гийн дурс нь 𠂇 тул хэрэв гадар хэлбэр дээрээ адил байхад хүрвэл урт a 𠂇 -г 𠂇 𠂇 гэх явдал болно.*)

Түүнд харин санскритын тухайн эгшгийн авиаалцын байдлыг тусгасан нь тодорхой байна – даруй бусад урт эгшгийн бичлэгтэй адилаар харгалзсан богино эгшигийг давхарлан бичсэн хэлбэр болно. Манж “али гали”-д харин өмнөх бага *a* -г << 𠂇 >> гэх шинэвтэр дурс (*үнэндээ энххүү дурс нь ч бас төвд үсгийн шанаган a (𠂇) -ийн дурсийн баруун хагас бичлэгийг дуурайн авсан байна.* Монгол “али гали”-д харин шанаган *a* (𠂇) -ийн зүүн хагас бичлэгийг авч монгол үсгийн урагшилга залгаж бүтсэн байна.) -ээр тэмдэглэж, санскритын урт *a*-г *𠂇* хэлбэртэй тэмдэглэсэн нь бага *a*-г урт эгшигийн үйлдэлтэй гэж үзсэний нэн тодорхой тусгал шиг байна. Учир << *ix a + bagaa a* >> гэсэн бүтэц бүхий << *𠂇* >> хэлбэр нь төвд үсэг дэх хэлбэр (*𠂇*)-тэй аргын хувьд нэгдэлтэй байна.

3) Манж “али гали” галиг ба монгол “али гали”-д санскрит төвдийн урт эгшигийг тэмдэглэсэн талаар зөрөөтэй байна. Монгол “али гали”-д санскрит хэлний урт эгшиг авианы олонхийг бүр харгалзсан богино эгшиг авианы үсгийг нь давхарлан бичих аргаар илтгэсэн байна. Тухайлбал, *𠂇 𠂇 ā 𠂇 ī 𠂇 ī 𠂇 ū 𠂇 ū 𠂇 ē* гэх мэт. Гэтэл

монгол “али гали”-д санскритын *o* эгшигийг << *𠂇* >> гэж тэмдэглэсэн ба’ *ō* эгшигийг

<<𠂊𠂊>>-аар тэмдэглэсэн нь зохиогчийн санскрит хэлний эгшиг *o*-г хос эгшигийн шинжтэй мөртөө бас урт эгшигийн шинжтэй байхыг тусгаж, *ō*-г маш урт эгшгэрээ үзсэнтэй холбоотой гэснийг бид тодорхойлж өнгөрсөн байна.⁴ Манж “али гали”-гийн зохиогч нь монгол “али гали”-д хэрэглэсэн харгалзсан богино эгшиг үсгийг нь давхарлан бичих аргыг хэрэглэн, *ā ī ū ū ī ē ō* мэтийн урт эгшигийг тэмдэглэх *ē* эгшигийг тэмдэглэхдээ <<𠂊>> (галиглавал *eī* буюу *ēī*) дүрсийг хэрэглэсэн байна. Тус <<𠂊>> дүрс нь аван үзэхэд монгол манж бичгийн <<𠂊>> *i* үсэг шиг боловч “*Tūn uṇy* юнь түн” бичиг дэх дүрсийг нь нарийн ажиглавал тэр нь <<𠂊>> дээр <<𠂊>> (*e + i*) нэмсэн бүтэцтэй байна. Тус үсгийн нурууны байдлаас үзвэл зохиогч түүнийг зориуд <<𠂊>> *i*-ээс ялгах гэсэн нь тодорхой билээ. Үүнээс гадна төвд хэлний эгшиг үсгийн тэмдэгүүдийг галиглахдаа манж “али гали”-д тун нэгдэлгүй байдалтай - төвдийн *u* эгшиг ба *o* эгшигийг галиглан тэмдэглэж байгаа байдал (энэ хоёр эгшигийг тус тус <<𠂊 <<𠂊>> -аар тэмдэглэсэн боловч бас монгол “али гали”-гийн дүрс <<𠂊𠂊𠂊𠂊>> -аар тэмдэглэх байдал “*Tūn uṇy* юнь түн” бичигт байн дахин илэрсэн) зэргийг хураангуйлж үзвэл, энэ нь нэг талаар “Мэргэд гарахын орон”-д өгүүлсэнчилэн санскритын *e o* эгшиг нь хос эгшигийн шинжтэй гэдэгтэй холбоотой байж мэднэ. Нөгөө талаар бас монгол “али гали”-гийн нөлөөг хүртсэн ч байж мэдэх юм.

4) Гийгүүлэгч үсгийг тэмдэглэсэн талаар, манж “али гали”-д санскрит төвд авиааны манж хэлэн дэх заншсан (буюу *oйролцоо*) дуудлагыг үндэслэн тэмдэглэсэн нь илүү. Тухайлбал, *ऋ tsa ḍṛ̥ tsha ḍṛ̥ zha ḍṛ̥ za ḍṛ̥ ha ḍṛ̥ za ḍṛ̥ cha ḍṛ̥ ja ḍṛ̥* ñа гэх мэт. Гэтэл, монгол “али гали”-д харин төвд үсгийн дүрс бичлэгийг дуурайн шинэ дүрс зохион хэрэглэсэн нь дийлэнх байdag. Жишээлбэл: *ऋ ū ḍṛ̥ ū ḍṛ̥ ū ḍṛ̥ ū tsa* *ऋ tsha ḍṛ̥ dsa ḍṛ̥ zha ḍṛ̥ za ḍṛ̥ ha ḍṛ̥ ū ha ḍṛ̥* гэх мэт. Өөрөөр хэлбэл, манж “али гали”-д манж үсэг ба манж үсгийн нэмэлт тэмдэг болох дусал бинт зэргийг илүүхэн хэрэглэхийг санаачилсан байхад монгол “али гали”-д харин төвд санскрит хэлэнд л байх онцгой авиаанд тохируулан төвд санскрит үсгийн хэлбэр дурсийг илүүхэн улируулан хэрэглэсэн байна.

⁴ čayansara. *a-a li g`a-a li üsüg-ün suduly-a.* ulayanbayatur., 2005 on. 32 duγar pīγur.

5) Манж “али гали”-гийн зохиогдон хэрэглэгдсэн нь монгол “али гали”-гийнхаас зуу гаруй жил хожуу боловч монгол “али гали”-ийн санскрит төвд хэлний авиааг буулган тэмдэглэх арга барил, түүний зарим дүрс бичлэг ба онцлог нь манж “али гали”-д нэлээд тусгалаа олсон байна. Жишээлбэл: Санскритын хэл матирах хамрын авиа *m-*

гийн дүрс << >>, төвдийн эгшиг үсгийн тэмдэгийн галигууд, бурхан шашны нэр томъёо буюу тарнийн үгийг үеэр нэгж болгон бичлэгээр нь буулгах гэх мэт.

Ерөнхийд нь үзвэл, манж үсгийн суурин дээр зохиогдсон манж “али гали” бол монгол “али гали”-тай адилаар тусгайлан бурхны нэр, номын нэр зэрэг бурханы шашны нэр томъёог орчуулахад зориулж зохиосон бичлэгийн галиг болох тул, тэр нь манж хэлний чухал туслагч багаж болсон манж үсгийн үйлдэл хэрэгцээг орлож чадахгүй нь мэдээжийн хэрэг юм. Гэтэл Жанжаа хутагтын найруулсан “*Tūn un' yon' tūn*” бичигт тус манж “али гали” анх эхлэн жагсаагдсанаас олон тооны бурханы ном судрын манж хэлний орчуулгад тун идэвхтэй хэрэглэгдсэн байна. Дээр тушаасанчлан манж “али гали”-гийн байдлаас үзвэл, Жанжаа хутагт монгол “али гали”-гийн зохиогдож хэрэглэгдсэн туршлагыг хувьсантуяаар хүлээн авч суралцан, санскрит, төвд, манж хэлнийхээ өргөн мэдлэгэд суурилан, манж үсгийн суурин дээр тус галигийг зохиосон байна. Манж “али гали”-д монгол “али гали”-ийн шиг төвд санскрит үсгийн дурсээс ирсэн тувэг будлиантай шинэ дүрсийг олон авч хэрэглэсэн биш, харин чадахын хирээр манж үсэгт уулаас байгаа үсгийн дүрс хэлбэрийн дээр шинэ манж үсэгт үүдэн хэрэглэсэн дусал бинтийг уялдуулан хэрэглэж дутагдаж байгаа галигийг нь нөхвөрлөсөн байна. Ингэснээс монгол “али гали”-г бодвол тэр нь дүрс бичлэгийн талаар дөхөм хялбар болж чадсан байна. Үүнээс гадна, монгол “али гали”-гаас сүүлээр бас тод галиг, халимаг галиг (*mən ch mod* “али гали”, халимаг “али гали” гэх) зэрэг бурханы ном судрын орчуулгад тусгайлан хэрэглэдэг галиг үсгүүд удаа дараалан илэрснийг бид дараачийн судалгааныхаа сэдэв болгон түр үлдээе.